



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 8/171

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Их хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 424 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хөвсгөл-Органик” бизнес эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10,000,000 (Арван сая) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөр”-ийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний зардлаас гаргаж, Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт дансанд шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ